



Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлж буй иргэдээс авсан 2023 оны 10-р сарын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс хүлээж буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ


- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний А заал 101 тоотоос иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.



СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Зураг1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс



Дүгнэлт: Орхон аймаг Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авахад 103 даатгуулагч хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 68.3 % эмэгтэй, 30.8% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.

Хүснэгт1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал

		Иргэдийн тоо	Хувь
Таны нас	20-29	7	6.7%
	30-39	42	40.4%
	40-49	23	22.2%
	50-59	29	27.9%
	60-аас дээш	2	2.0%
Нийт үр дүн		103	100%


Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн насны хувьд авч үзвэл 20-29 насны 7 даатгуулагч, 20-29 насны 42 даатгуулагч, 40-49 насны 23 даатгуулагч, 50-59 насны 29 даатгуулагч, 60-аас дээш насны 2 даатгуулагч судалгаанд хамрагдсан байна. Орхон аймаг Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн ихэнх хувь нь 30-39 насныхан буюу 40.4% байна.



Хүснэгт2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээний төрөл

		Иргэдийн тоо	Хувь
Та нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ ирсэн бэ? ямар авахаар	Тэтгэвэр төлөлт	23	22.1%
	Тэтгэмж	3	2.9%
	Сайн дурын даатгал	19	18.3%
	Нийгмийн даатгалын шимтгэл	17	17.3%
	Зөвлөгөө мэдээлэл	12	11.5%
	Бусад.....	29	27.9%
Нийт үр дүн		103	100%

График1: Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээ авсан иргэдийн төрөл, хувь хэмжээ




Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн 23 даатгуулагч (22.1%) нь тэтгэвэр төлөлт ,тэтгэмжтэй холбоотой мэдээлэл 3 даатгуулагч (2.9%), сайн дурын даатгалтай холбоотой мэдээлэл 19 даатгуулагч (18.3%), нийгмийн даатгалын шимтгэл 17 даатгуулагч (17.3%),Зөвлөгөө мэдээлэл 12 даатгуулагч (11.5%), бусад 29 даатгуулагч (27.9%) тус бүр үйлчилгээ авсан байна.

**Хүснэгт3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ шуурхай, хялбар**

	Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын байгууллага үйлчилгээ шуурхай, хялбар байсан уу%	Маш сайн	36 34.6%
	Сайн	63 60.6%
	Дунд	4 3.8%
	Муу	-
	Маш муу	-
Нийт үр дүн	103	100%


Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн 36 даатгуулагч маш сайн үнэлгээг өгсөн (34.6%), сайн үнэлгээг 63 даатгуулагч буюу (60.6%), дунд үнэлгээг 4 даатгуулагч буюу (3.8%) тус бүр өгсөн байна. Муу, маш муу гэсэн үнэлгээг иргэд өгөөгүй нь нийгмийн даатгалын үйлчилгээ хялбар, түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж байна.

Зураг2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл авсан үнэлгээ

Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн “Тийм” гэсэн үнэлгээг 102 даатгуулагч буюу (98.1%), “Үгүй” гэсэн үнэлгээг 1 даатгуулагч (1%) хэмээн үнэлгээг тус бүр өгсөн байна.



График2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн зөвлөгөө, ажилтны харилцаа, хандлага үнэлгээ



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн сэтгэл ханамжтай 101 даатгуулагч буюу (97.1%), сэтгэл дундуур 2 даатгуулагч (1.9%), сэтгэл ханамжгүй үнэлгээг сонгоогүй .Үүнд: “Сэтгэл ханамж өндөр үзүүлэлттэй гарж байна.

График3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл ил тод байдал\Төлөвлөгөө, тайлан, хүний нөөц,худалдан авах ажиллагаа ..\




Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн “Тийм” үнэлгээг 34 даатгуулагч буюу (32.7%),”Үгүй” үнэлгээг 35 даатгуулагч буюу (33.7%),Мэдэхгүй үнэлгээг 34 даатгуулагч буюу (32.7%) тус бүр үнэлсэн байна.



График4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн ойр дотны хамаатан садан, найз нөхөд ажилладаг бол түүгээр дамжуулан үйлчилгээ


Нийгмийн даатгалын байгууллагад таны ойр дотны хамаатан садан, найз нөхөд ажилладаг бол түүгээр дамжуулан үйлчилгээ авч байсан уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн “Тийм” үнэлгээг 6 даатгуулагч буюу (5.8%), “Үгүй” үнэлгээг 97 даатгуулагч буюу (93.8%) тус бүр үнэлсэн байна. Энэ нь иргэд эрх тэгш үйлчилгээг дэс дараалалттай авч байна .

График5: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ үзүүлэх

Та нийгмийн даатгалын үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг өгөх, хандив туслалцаа үзүүлж байсан уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн “Тийм” үнэлгээг 4 даатгуулагч буюу (3.8%), “Үгүй” үнэлгээг 99 даатгуулагч буюу (95.2%) тус бүр үнэлсэн байна. Шуурхай шударга үйлчилгээ үзүүлсэн байна.



Та төрийн байгууллагын авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх хэрэгтэй гэж үзэж байна вэ?



- ✓ Ил тод нээлттэй байх
- ✓ Мэдээлэл нээлттэй шударга зарчимд суурилах
- ✓ Төр засаг хуулиа зөв болгох хэрэгтэй
- ✓ Үнэнч шударга байх
- ✓ Хуулийн дагуу ажиллахад болно
- ✓ Шударга байдал эрх тэгш
- ✓ Шударга ёс тогтоох

Судалгааны нэгтгэл хийсэн:/Ө.Нэргүй /